



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/549

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай 2023 оны А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны “Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай” А/04 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулах ашгийн төлөө бус хуулийн этгээдийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Р.Машбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Д.Нямжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Ч.Ганчимэг (Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Сонгон шалгаруулалтын хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Р.Машбат)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011235